

АМЬШУУЛАХ ҮЗЭЛ ГАЗАР НУТГИЙН НЭРЭНД*Г.Амарзаяа**

Амьшуулал буюу анимизм гэсэн үг нь латин хэлний anima буюу сүнс, дотоод сэтгэл гэсэн үгнээс гаралтай. Амьшуулах үзлийг дагагчид бүх биет нь амьшсан, сүнсжсэн ба уул, гол гэх мэт зарим зүйлс үнэндээ бурхан сахиусын сүнсийг тээж явдаг гэдэгт итгэдэг. [22]

Wikipedia нэвтэрхий тольд бичсэнээр амьшуулал гэсэн нэр томъёог сүнсийг хүн төрөлхтөнөөс гадна амьтан, ургамал болон бусад нэгжүүдэд хамааруулан үздэг үзэл гэж үзэх нь түгээмэл гэжээ. Амьшуулал нь мөн сүнсийг байгалийн үзэгдэл, газар зүйн биет, өдөр тутмын зүйлс болон үйлдвэрлэгдсэн зүйлд хамааруулдаг. Илүү ерөнхийлэн хэлбэл, анимизм бол зүгээр л сүнсэнд итгэх үзэл юм. Энэхүү ерөнхий утгаараа анимизм нь бараг бүх шашинд байдаг. Британийн хүн судлаач Эдвард Бурнетт Тайлор “Балар эртний соёл” бүтээлдээ (1871) энэ үзэл бол хамгийн балар эртнийх бөгөөд шашны нэн чухал хэсэг гэж үзжээ. Хэдийгээр амьшуулал нь өөрөө ердийн Барууны утгаараа шашин биш боловч зарим эрдэмтэд шашнуудын бий болсон суурь үндэс үнд агуулагддаг гэж итгэдэг. [21]

Амьгүй зүйлд амийг хамааруулан үзэхийг “Шашны байгалийн түүх” бүтээлдээ Хюм зөвтгөсөн байдаг. “Хүн төрөлхтөний дунд бүх зүйлийг өөрсөд шигээ төсөөлдөг бөгөөд бүр рүү шилжүүлдэг ерөнхий хандлага байдаг.” [20]

Сэтгэл судлаач Зигмунд Фрейд “балар эртний хүмүүс” унтах (бас зүүдлэх) болон үүнтэй маш их төсөөтэй үхэх үзэгдлийг ажиглан эдгээрийг тайлбарлахыг оролдох явцдаа амьшуулалын системтэй тулгарсан гэж үзжээ. Бодол эргэцүүллийг өдөөсөн үзэгдэлтэй тулгарахаараа сүнсний санааг бий болгож улмаар үүнийгээ гадаад ертөнц дэх биетүүд рүү өргөтгөн тэлдэг нь хүний төгс байгалийн чанар гэж Фрейд үзжээ. Э.Б.Тайлор, Нерберт Спенсер, Андрей Ланг болон бусад хүмүүс “бүдүүлэг”-үүдийн амьшуулалд итгэхэд хүргэсэн үзэгдлүүдийн жагсаалтыг гаргажээ. Үүнд: ховсдол, ухаан алдалт, өвчин, үхэл, далдыг харах мэдэх явдал, зүүд, үхсэн хүмүүсийн сүг сүнс, хий юм үзэх сонсох, цуурай, сүүдэр, эргэцүүлэл багтаж байна.

Амьшуулалын уугуул санаа нь балар эртний хүмүүсийнх байсан гэсэн үзэлтэй хүмүүс олон. Британийн хүн судлаач Эдвард Бурнетт Тайлор “Балар эртний соёл шашны хамгийн доод тодорхойлолт” гэж тооцжээ. Тэрээр хамгийн энгийнээс авхуулаад хамгийн түвэгтэй хүртэлх бүх шашинд амьшуулалын үзэл ямар нэгэн хэмжээгээр байдаг гэжээ.

* Г.Амарзаяа - ХИС-ийн ГХСС

Түүнийхээр бол бичгийн соёлгүй байсан гэж тодорхойлогддог балар эртний хүмүүс сүнс болон хий үзэгдэлүүд нь хүн төрөлхтөний амьдралын учир шалтгаан гэж итгэдэг байжээ. Тэд нар эдгээр сүнсүүдийг нэг биеэс нөгөө рүү явж байгаа уур манан, сүүдэр гэж дүрсэлдэг байжээ. Сүнсүүд нь зөвхөн хүн төрөлхтөний дунд дамждаггүй мөн ургамал руу, амьтан руу, мөн амьгүй зүйл рүү дамждаг гэдэг байжээ.

Балар эртний хүмүүст Тайлорын хэлж байгаа шиг тийм хамгийн энгийн тайлбарыг ч хийх оюуны чадавх хөгжөөгүй байсан гэж үздэг Британийн өөр нэг хүн судлаач Роберт Раналф Маретт (1866-1943) Тайлорыг шүүмжилсэн байдаг. Маретт эртний шашин нь илүү сэтгэл хөдлөлийн шинжтэй, гарал үүслийн хувьд зөн билгийн байсан гэсэн санааг дэвшүүлсэн байдаг. Эртний хүмүүс бүх амьтай зүйлийг өөрсдийн амьдрал, хүсэлтэй гэж ханддаг байсан боловч хэзээ ч сүнсийг биенээс салангид бөгөөд биенд ордог, түүнээс гарч явдаг гэж ялгаж үзэж байгаагүй гэж тэр үздэг байжээ. Маретт эртний хүмүүсийг амьшуулалын үзэлтэй байсан гэдгийг хүлээн зөвшөөрч байсан ч энэ нь зарим зүйлс хүн шиг амьд юм шиг санагддаг байсан санаанаас гаралтай гэжээ. [23]

Орчин үед анимизм нь ихэнх шашин болон шинэ үеийн аман зохиолд хамгийн нийтлэг. Ялангуяа бөө мөргөл гэх мэт уламжлалтай хүмүүсийн дунд түгээмэл. Анимистууд дов толгод, хөндий, усан замууд, хад чулуунууд мөн ургамал, амьтад нь сүнслэг биетүүд гэж итгэдэг. Чухам л энэ үзлийн ул мөр газар нутгийн нэр, чухамдаа монгол газар нутгийн нэрийн үгийн сангийн бүрэлдэхүүнд тодоор илэрдэг бөгөөд бидний судалгааны гол зорилго нь үүнийг батлах, баримтжуулах явдал байлаа.

Э.М.Мурзаевын “Очерки топонимики”, “Анатомическая лексика в народо́й географической терминологии”, “Словарь народных географических терминов” зэрэг бүтээлүүд, В.Д.Колесниковагийн “Названия частей тела человека в Алтайских языках”, “Britannica Macropedia”, “The New Encyclopedia Britannica”, Б.К.Ондарийн “Топонимический словарь Тувы” толийн баримт, интернетийн мэдээлэл зэрэг нь хүн, амьтны бие эрхтний нэр нь олон улс үндэстнүүдийн газар нутгийн нэрэнд байдгийг тодорхой харуулсан байна.

Газар нутгийн оноосон нэр нь юуны өмнө хүний бие эрхтэн, сав суулга, нэхмэлийн машин, барилга байгууламж, түүний бүрэлдэхүүн хэсэг, цаг агаарын үзэгдлийн нэртэй байдаг тухай Н.И.Толстой (Толстой, 1969), Н.Кадмон (Kadmon, 2000) нар өгүүлсэн нь бий. Түүнчлэн Э.М.Мурзаев хүн амьтны бие эрхтний нэрээр азербайжан, орос, казак, араб, армян, монгол, уйгуур, балкар, түрэгмен, чукот, хятад, түрэг, вьетнам, тажик, солонгос, перс зэрэг хэлэнд газрын биетийг нэрлэдэг тухай тодорхой баримтаар нотлон өгүүлжээ. [4]

“Britannica Macropedia” тольд: Heart river- гэдэг гол АНУ-ын Хойд Дакотогийн Биллинг мужийн Бадландад байдаг тухай, тэнд мөн Heart

Butte Dam гэж бий талаар өгүүлжээ. (The New Encyclopedia Britannica, volume 6) Энэ тольд мөн Liverpool - Канадийн зүүн өмнөд Нова Скотиагийн Киюнс муж дахь хот, Livermore- АНУ-ын баруун Калифорниагийн Аламеди мужийн хот, Livermore-Amador гэдэг хөндий, Liverpool- Нэгдсэн Вант улсын 7 дахь том хот бөгөөд Мерсисайдын бүсийн төв, далайн боомт хот зэрэг баримт байна. [The New Encyclopedia Britannica, volume 7]

Монголоор (хүний, уулын) **ар, нуруу**: латинаар *dorsum* (хүний, уулын нуруу), эртний герегийн *gaxis* (хүний болон уулын нуруу); англи хэлний *back* (хүний болон уул, толгойн нуруу), *chine* (мал, амьтны нуруу, уулын хяр); болгар хэлний *гръб* (хүн болон уул, толгойн сэрвэн нуруу); казах, уйгуур хэлний *арка* (хүн болон уулын нуруу), түрэг хэлний *sirt* (хүн болон уртавтар уул, ухаа); орос хэлний *спинной хребет - горный хребет* (хүний болон уулын сэрвэн нуруу) гэх мэт литов, латыш, финн, осетин хэлэнд дээрх байдлаар адил нэрлэдэг ажээ гээд *ам, хамар, хоолой, толгой* гэсэн үгсийн дэээрхийн адил жишээнүүдийг дурджээ. [13]

Оросын газар нутагт хэрэглэгддэг 4264 газар зүйн нэр томъёоны хувилбар бүхий Э.М.Мурзаевын “Словарь Народных Географических терминов” толиос шүүж үзэхэд 85 эрхтний 185 хувилбар (*ам, хөл, нуруу, нуд, хамар, нуур, хоолой, гар, хуруу, бүсэлхий, бөөр, хавирга, хэл* гэх мэт) байна. Тухайлбал, *ам* нэрийн 17 үндэстний хэрэглэдэг 18 хувилбар, *нуд* нэрийн 2 үндэстний хэрэглэдэг 2 хувилбар, *шуд* нэрийн 4 үндэстний хэрэглэдэг 5 хувилбар гэх мэт бүртгэгджээ. [Э.М.Мурзаев 1984]

Б.К.Ондарын “Топонимический Словарь Тувы” тольд нийт 141 газар нутгийн суурь буюу дэвсгэр нэр орсноос 29 нь буюу 20.5 хувь нь хүн, амьтны бие эрхтний нэр байна. [Б.К.Ондар 2004]

Ингэхлээр байгалийг амьшуулах сэтгэлгээ зөвхөн Монголын газар нутгийн нэрэнд ч биш бусад үндэстэнд ч бас байсан байгаа боловч энэ нь эдүгээ хүртэл хэрэглэнд ийм түгээмэл хэвээр үлдсэн нь монгол газар нутгийн нэрийн нэгэн онцлог юм.

Хүнд хамаатай нэрийн бүрэлдэхүүн нь монголын газар нутгийн нэрэнд томоохон байрыг эзэлдэг. “Бөөгийн болон бурхны шашны үзэл монгол газар нутгийн нэрэнд туссан нь” өгүүлэлдээ Э.Равдан 70-80 оны газар нутгийн нэр бүхий Монгол газар нутгийн нэрийн зүйлчилсэн тольд (5 боть 8 дэвтэр) *ам-29966, багалзуур-1, боом-62, бөгс-19, гуя-1* гэсэн 32 дэвсгэр буюу суурь нэр, 30-40 оны газар нутгийн нэр бүхий Монгол газар нутгийн нэрийн зүйлчилсэн тольд (2 боть) *ам-560, бөгс-2, булуу-11, гуя-3, дух-4, зоо-48* гэсэн 27 дэвсгэр буюу суурь нэр, Манжийн үеийн газар нутгийн нэр бүхий Монгол газар нутгийн нэрийн зүйлчилсэн тольд (1 боть) *ам-45, булуу-1, гуя-1, дух-1, зоо-1, нуруу-158* гэсэн 21 дэвсгэр буюу суурь нэр байна гээд тольд гарсан давтамжаар нь гаргасан байгааг шүүж харвал давхардаагүй тоогоор 35 нэр оржээ.

Харин бидний шүүлтээр эдгээр 35 нэрээс гадна *ар, ац, гануу, давхраа, залаа, нурган, орой, өвөр, сав, салаа, суу, сүвээ, сэртэн, таваг, туруу, уушиг, хаа, хажуу, ховдол, хоол, хуудас, хушуу, хуйс, энгэр* гэсэн 24 бие эрхтний нэр мөн дэвсгэр нэр болж байна. Энд *нурган, суу, хоол, хушуу* гэсэн нэрс нь *нуруу, суга, хоолой, хошуу* гэсэн үгсийн нутгийн аялга хувилбар нь тул багтаан үзсэн болно. Ингэхлээр эдгээр толиудад давхардаагүй тоогоор нийт 484 дэвсгэр нэр тэмдэглэгдсэн байдгаас 59 нь буюу 12.19% нь хүн амьтны бие эрхтэн заасан нэр байна.

Мөн дээрх өгүүлэлд монгол газар нутгийн нэрэнд хүн ба амьтны бие эрхтний нэрс оноосон гишүүний үүргээр орсон нь тоо болон утгын хувьд үлэмж байгаа бөгөөд монголчууд энэхүү оноосон нэрээр тодотгож байгаа газрын уг биетийн байршил, хэлбэр дүрс, өнгө зэргийг өөрийн болон амьтны бие эрхтэнтэй дүйлгэн нэрлэдэг нь маш эртний улбаатай гээд давтамжтай нь *аарцаг-5, араа-4, арьс-4, алга-5, ам-74, аюулхай-3, бие-13, борви-7, бөгс-19, бугуй-1, булчирхай-1* зэрэг болно гэж 98 нэр оруулсан байна.

Бидний шүүлтээр монгол газар нутгийн нийт дэвсгэр болоод оноосон нэрэн дотор хүн амьтаны бие эрхтний 200-гаад нэр байгаа бөгөөд үнд тулгуур ба ясан эрхтнүүд, толгой, нүүр, нүүрэн талын эрхтнүүд, дотоод эрхтнүүд болон 5-н цул, гадаад эрхтнүүд, ар нуруу талын эрхтэн зэрэг бүх төрлийн бие эрхтний нэр орсон байна.

Шүүлтээр нэмж оруулсан бие, эрхтний нэрсийг дурдвал *ар, ац, аюулхай, багалуур (багалзуур), багалзуур, бамбай, баруунсуу (баруун суга), бахлуур (багалзуур), бойм, боов, бөх, буйл (буйл), булчин (булжим), бураа, гануу, годон, голгой (олгой), гос, гэдэс, гэээг, давхараа, жавьж, засаа, лэг, мах, намайлдаг, нугас, нурган (нуруу), омруу (энгэр), оошиг (уушиг), өвөр, өвчүү, өд, өлөн, өндөг, өөх, өрөг (эруу), өрүү (эруу), өсгий, сав, шанх, шир, шуу, шүүж (сууж), элх (элэг), энгэр, ээм (мөр), ээрцэг (аарцаг)* зэрэг 100 гаруй нэр болно. Энд мөн дээрхийн адил *уушиг* гэдэг үгийн нутгийн аялга хувилбар *оошиг, энгэр* үгийн хувилбар *омруу, нуруу* үгийн хувилбар *нурган, багалзуур* үгийн хувилбар *бахлуур, эруу* үгийн хувилбар *өрөг, сууж* үгийн хувилбар *шүүж, элэг* үгийн хувилбар *элх, мөр* үгийн хувилбар *ээм, аарцаг* үгийн хувилбар *ээрцэг* зэрэг багтсан байгаа.

Хүн ба амьтны бие эрхтний нэр нь хүний оноосон нэр, гадаад дүр төрхийн нэр зэргээсээ утгын хувьд илүү өргөн хүрээтэй нь ажиглагдаж байна. Тухайлбал, газар нутгийн нэрэнд тэр дундаа уулын хувьд авч үзвэл *нуур, зулай, магнай, дух, өвчүү, энгэр, омруу, бэл, санчиг* гэвэл уулын наран ээвэр буюу өвөр талыг; *дал, дагз, шил, зоо, сэrvээ, сэртэн* гэвэл сүүдэр буюу ар талыг; *шанаа, мөр, хавирга, сүвээ, сууж, бөөр, тунх* гэвэл хажуу талыг байхаар бодолцон байршлаар нь нэрлэсэн, *зурх, элэг, сархинаг, хошуу, ам, гүзээ, хамар* гэж тухайн

эрхтний өнгө, дүрстэй дүйлгэсэн байж болох үзэгдэл монголын газар нутгийн нэрэнд түгээмэл оршиж байгаа бөгөөд яг ямар учраас нэрлэснийг үндэслэлтэйгээр тогтооход нарийвчилсан судалгаа хэрэгтэй.

Монголын газар нутгийн нэрэнд орсон хүн амьтны бие эрхтний 200-гаад нэрнээс 60 орчим нь буюу 30% нь газар нутгийн дэвсгэр нэрийн үүргээр хэрэглэгдэж байгаа бөгөөд энэ нь Э.Равдангийн эмхэтгэн гаргасан 3-н үеийн 11-н дэвтэрт орсон нийт 484-н дэвсгэр нэрийн (давхардаагүй тоогоор) 13 орчим хувийг эзэлж байгаа нь хүн амьтантай холбоотой бүх нэр биш зөвхөн бие эрхтний нэрийг авч үзсэн гэхэд харьцангуй өндөр хувь байна.

Монгол газар нутгийн нэрийн зүйлчилсэн толины 70-80-аад оны 5-н боть 8-н дэвтэрт байгаа нийт 214805 нэрийн 77134 нь буюу 35.9 хувь нь хүн амьтны бие эрхтний нэр оролцсон нэр байгаа нь бие эрхтний нэр монгол газар нутгийн нэрэнд ямар байр эзлэх вэ гэдгийг харуулж байгаа нэг нотолгоо болж байна.

Хүн амьтны бие эрхтнээр нэрлэгдсэн газар нутгийн дэвсгэр нэрсийг газар нутгийн нэрийн олон улсын ерөнхий ангилалд оруулж үзвэл:

Уулын тухайт дэвсгэр нэр [46]: *ам, ар, боом, бөгс, гануу, гуя, дух, зоо, магнай, нурган, нуруу, нуур, орой, өвдөг, өвөр, суга, суу, сүв, сүвээ, сууж, сүүл, сэрвэн, сэртэн, сээр, таваг, тархи, толгой, уушиг, узуур, хавирга, хажуу, хамар, хацар, хондлой, хоол, хоолой, хошуу, хөл, хуруу, хуудас, хушуу, хузуу, хүйс, шанаа, шил, энгэр*

Усны тухайт дэвсгэр нэр [5]: *ац, боом, сав, салаа, тохой, хузуу*

Газрын тэгш, хотгор гадаргуутай холбоотой нэр [6]: *давхраа, сүв, ховдол, хоол, хоолой, хэвэл,*

Хот суурин, хүн ам суурьшсан газрын нэр: байхгүй

Ургамлын аймагтай холбоотой нэр: байхгүй

Тодорхойгүй нэр [5]: *багалзуур, булуу, залаа, олгой, хаа* байна.

Энэ ангилалаар ялгаж үзвэл монгол газар нутгийн нэрэнд дэвсгэр болон оноосон нэрийн үүргээр орж байгаа хүн амьтны бие эрхтний 59 нэрийн 46 нь буюу 77.9% нь уулийн тухайт дэвсгэр нэрт хамаарч байна. Цаашилбал, бусад 5 дэвсгэр нэр нь урсгал болон тогтмол усны тухайт нэр биш харин устай холбоотой өөр газар нутгийн нэр, 6 дэвсгэр нэр нь газрын тэгш, хотгор гадаргуутай холбоотой нэр байна.

Ингээд эцэст нь тэмдэглэхэд бүх шашны үндэс гэж тооцогддог эртний улбаатай амьшуулах үзэл нь бусад орны газар нутгийн нэрэнд илэрдэг хэдий ч монгол газар нутгийн нэрэнд нэлээн түгээмэл байдлаар илэрдэг бөгөөд ингэж илрэхдээ уулын тухайт нэрэнд харьцангуй давамгай буюу 77% -д нь хэрэглэгддэг нь монголчууд ус, голоосоо илүү уул, нурууг амьтай хэмээн үздэг байсныг баталж байна.

Түүнчлэн аливаа улс, үндэстний газар нутгийн нэрс нь түүний түүхийн олон баримтын илэрхийлэл тул газар нутгийн нэрэнд хэрэглэгдэж буй хүн,

амьтны бие эрхтний нэр бүрийг утгазүй, үгзүй, үгийн сангийн үүднээс болон гарал үүслээр нь нарийвчлан судалж үзвэл олон сонирхолтой, шинжлэх ухааны ач холбогдолтой баримт илрэх нь зайлшгүй.

Ном зүй

1. Батсүрэн.Ч. Монгол хэлний малын тухайт үгс, түүгээр газар нутагаа нэрлэсэн байдалд хийсэн үгийн сан-утга зүйн судалгаа. Диссертаци. УБ., 2006.
2. Далай.Ч. Монголын бөөгийн мөргөлийн товч түүх. УБ., 1959.
3. Дулам.С. Монгол домог зүйн дүр. УБ., 1989.
4. Мурзаев.Э.М. Очерки топонимики: Анатомическая лексика в народной географической терминологии., 1974. 126-134с.
5. Мурзаев.Э.М. Словарь Народных Географических терминов. Москва., 1984
6. Норжин.Ц. (эмхтгэсэн) Монгол хэлний толь., Өвөрмонголын Ардын хэвлэлийн хороо., 1997.
7. Ондар.Б.К. Топонимический Словарь Тувы. Абакан., 2004
8. Равдан.Э. Монголын газар нутгийн нэрийн хэлбэр-утгазүйн судалгаа УБ., 2004.
9. Равдан.Э. Монголын газар нутгийн нэрийн зүйлчилсэн толь (70-80 оны үе) УБ., 2004. (5-н боть 8-н дэвтэр)
10. Равдан.Э. Монголын газар нутгийн нэрийн зүйлчилсэн толь (30-40 оны үе) УБ., 2004. (2 боть)
11. Равдан.Э. Монголын газар нутгийн нэрийн зүйлчилсэн толь (Манжийн үе) УБ., 2004.
12. Равдан.Э. Бөөгийн болон бурхны шашны үзэл монгол газар нутгийн нэрэнд туссан нь.
13. Равдан.Э. Монгол газар нутгийн нэр зүй УБ., 2008.
14. Пүрэв.О. Монгол бөөгийн шашин. УБ., 1999.
15. Сүхбаатар О. Монголын тахилгат уул усны судар оршвой. УБ., 2001. 10-14.
16. Толстой.Н.И. Славянская географическая терминология: Семасиологические этюды. М., “Наука”, 1969, 262 с.
17. Цэвэл.Я. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 1966.
18. Шагж.Монгол үгийн тайлбар толь., Монгол улсын соёлын сан. Дундад улсын үндэсний хэвлэлийн хороо., 1994.
19. Kadmon.N. Toponymy. The Lore, Laws and Language og Geographical Names, New York, 2000, 334p
20. The New Encyclopedia Britannica, volumes 6, 11, 26 Micropedia. USA., 1995.
21. Tylor, Edward. 1970 [1871]. Primitive Culture. New York: J.P.Putnam’s Sons.1.
22. www.en.wikipedia.org/wiki/animism
23. www.themystica.com/mystica/articles/animism